

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/71НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.opendatalab.mn
Улаанбаатар хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: 70373089, 99023682
Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn
Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит
ХХК
Утас: 99197346, 88114867 Цахим хаяг:
Shinjenmagadlahui.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	
5.2 Албан шаардлага	
5.3 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.05 № 103
танай _____ -ны № _____ -т

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О.НАНДИН-ЭРДЭНЭ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 61.6 хувийг цалин хөлс, 38.3 хувийг нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, бараа үйлчилгээний бусад зардал, 0.1 хувийг урсгал засварын зардал тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020150

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус цэцэрлэгийн цалингийн зардал 282,436.8 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 29.3 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Дархан сумын 5 дугаар цэцэрлэг нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилгын хүрээнд 7 зорилтыг төлөвлөж, хэрэгжилт 98 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР


2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	181,904,434.58	384,992,969.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	108,023,416.19	282,839,885.31
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	108,023,416.19	282,839,885.31
3121	Төгрөг	108,023,416.19	282,839,885.31
31211	Төрийн сангийн харилцах	108,023,416.19	282,839,885.31
35	БАРАА МАТЕРИАЛ	73,881,018.39	102,153,084.39
351	Түүхий эд материал	2,407,540.00	2,322,210.00
35130	Эм боох материал	2,407,540.00	2,322,210.00
354	Хангамжийн материал	71,473,478.39	99,830,874.39
35410	Бичиг хэргийн материал	841,500.00	949,400.00
35420	Аж ахуйн материал	51,227,123.40	78,635,824.40
35450	Барилгын засварын материал	828,200.00	789,700.00
35460	Хүнсний материал	3,998,694.99	6,568,689.99
35470	Бусад хангамжийн материал	14,577,960.00	12,887,260.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,374,469,523.12	1,426,653,564.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,374,469,523.12	1,426,653,564.22
392	Биет хөрөнгө	1,050,043,523.12	1,102,477,564.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,218,027,589.92	1,294,122,718.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(256,291,258.03)	(307,971,601.99)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,748,187.50	91,557,344.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,805,434.33)	(28,636,323.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,171,015.07	29,968,515.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,203,625.46)	(17,820,906.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,955,177.19	44,306,147.19
39215	Хуримтлагдсан элэгдэл	(48,000,634.36)	(5,490,834.24)
39217	Ном	2,442,505.62	2,442,505.62
393	Биет бус хөрөнгө	324,426,000.00	324,176,000.04
39301	Програм хангамж	2,124,300.00	2,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,374,299.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	323,426,000.00	323,426,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,556,373,957.70	1,811,646,533.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,556,373,957.70	1,811,646,533.92
51	Засгийн газрын хувь оролцоо	871,767,165.00	871,767,165.00
512	Хуримтлагдсан үр дүн	(543,793,900.26)	(288,521,324.04)
51210	Өмнөх үеийн үр дүн	(572,517,273.23)	(543,793,900.26)
51220	Тайлант үеийн үр дүн	28,723,372.97	255,272,576.22
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,228,400,692.96	1,228,400,692.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,556,373,957.70	1,811,646,533.92



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,190,662,635.74	1,720,245,803.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,452,619.00	158,532,203.00
120	Нийтлэг татварын бус орлого	53,452,619.00	158,532,203.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,628,600.00	49,195,574.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39,628,600.00	49,195,574.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	2,560,000.00	109,336,629.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	4,264,019.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,137,210,016.74	1,561,713,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,091,855,900.00	1,495,775,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,091,855,900.00	1,495,775,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,354,116.74	65,938,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,354,116.74	65,938,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,161,741,262.77	1,464,973,226.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,161,741,262.77	1,464,973,226.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,132,865,962.77	1,462,475,219.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,689,682.00	961,126,489.11
210101	Үндсэн цалин	454,032,650.66	662,022,730.84
210102	Нэмэгдэл	194,688,450.30	262,234,599.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	29,968,581.04	39,869,159.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,135,069.72	121,557,785.77
210201	Тэтгэврийн даатгал	61,459,946.24	83,140,637.55
210202	Тэтгэмжийн даатгал	7,217,724.14	9,857,948.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,749,963.30	4,839,874.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,426,420.94	4,649,571.08
210205	Эрүүл мэндийн даатгал	14,281,015.10	19,069,754.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,054,116.74	47,440,392.76
210301	Гэрэл, цахилгаан	10,741,917.07	11,719,216.91
210302	Түлш, халаалт	24,024,982.13	23,746,482.21
210303	Цэвэр, бохир ус	9,287,217.54	11,794,693.64
2104	Хангамж, бараа материалын зардал	10,149,460.00	16,229,339.00
210401	Бичиг хэрэг	7,290,450.00	6,810,825.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,859,010.00	9,418,514.00
2105	Нормативт зардал	155,593,140.00	188,458,791.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	689,300.00	335,330.00
210502	Хоол, хүнс	154,903,840.00	185,123,461.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,288,515.00	19,736,310.00

210604	Урсгал засвар	55,288,515.00	19,736,310.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,278,945.00	3,112,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,278,945.00	3,112,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,677,034.31	107,813,311.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,969,330.00	10,858,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,707,704.31	96,954,661.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,875,300.00	2,498,007.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,875,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,875,300.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,498,007.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,498,007.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>28,921,372.97</u>	<u>255,272,576.22</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	198,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	198,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(198,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>28,723,372.97</u>	<u>255,272,576.22</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,144,210,016.74</u>	<u>1,561,713,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	7,000,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,000,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,137,210,016.74</u>	<u>1,561,713,600.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,091,855,900.00	1,495,775,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,091,855,900.00	1,495,775,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,354,116.74	65,938,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,354,116.74	65,938,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,049,563,573.46</u>	<u>1,386,538,130.88</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,049,563,573.46	1,386,538,130.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,020,688,273.46	1,384,040,123.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,689,682.00	961,126,489.11
210101	Үндсэн цалин	454,032,650.66	662,022,730.84
210102	Нэмэгдэл	194,688,450.30	262,234,599.18
210104	Урамшуулал	29,968,581.04	36,869,159.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,135,069.72	121,557,785.77
210201	Тэтгэврийн даатгал	61,459,946.24	83,140,637.55
210202	Тэтгэмжийн даатгал	7,217,724.14	9,857,948.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,749,963.30	4,839,874.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,426,420.94	4,649,571.08
210205	Эрүүл мэндийн даатгал	14,281,015.10	19,069,754.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,054,116.74	47,440,392.76
210301	Гэрэл, цахилгаан	10,741,917.07	11,719,216.91
210302	Түлш, халаалт	24,024,982.13	23,746,482.21
210303	Цэвэр, бохир ус	9,287,217.54	11,974,693.64
2105	Нормативт зардал	154,797,600.00	187,693,456.00
210502	Хоол, хүнс	154,797,600.00	187,693,456.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	16,000,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	16,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,278,945.00	4,659,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,278,945.00	4,659,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,432,860.00	45,562,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,769,360.00	30,800,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,663,500.00	14,762,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>28,875,300.00</u>	<u>2,498,007.24</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,875,300.00	-

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,875,300.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,498,007.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,498,007.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>94,646,443.28</u>	<u>175,175,469.12</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,750,000.00	359,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,750,000.00	359,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,750,000.00	359,000.00
222001	Тоног төхөөрөмж	1,750,000.00	359,000.00
223001	Бусад хөрөнгө	1,000,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,750,000.00)</u>	<u>(359,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	91,896,443.28	174,816,469.12
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,126,972.91	108,023,416.19
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	108,023,416.19	282,839,885.31

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	871,767,165.00	1,228,400,692.96	(572,517,273.23)	1,527,650,584.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	871,767,165.00	1,228,400,692.96	(572,517,273.23)	1,527,650,584.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	28,723,372.97	28,723,372.97
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,767,165.00	1,228,400,692.96	(543,793,900.26)	1,556,373,957.70
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	871,767,165.00	1,228,400,692.96	(543,793,900.26)	1,556,373,957.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	871,767,165.00	1,228,400,692.96	(543,793,900.26)	1,556,373,957.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	255,272,576.22	255,272,576.22
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,767,165.00	1,228,400,692.96	(288,521,324.04)	1,811,646,533.92

ХТ05430@9822899


2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ
/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,677,389,700.00	1,384,399,123.64	(292,945,576.36)	82.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,677,389,700.00	1,384,399,123.64	(292,945,576.36)	82.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,677,389,700.00	1,384,399,123.64	(292,945,576.36)	82.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,201,494,500.00	961,126,489.11	(240,368,010.89)	79.99
210101	Үндсэн цалин	863,001,200.00	662,022,730.84	(200,978,469.16)	76.71
210102	Нэмэгдэл	314,565,300.00	262,234,599.18	(52,330,700.82)	83.36
210104	Урамшуулал	23,928,000.00	36,869,159.09	12,941,159.09	154.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,418,300.00	121,557,785.77	(15,860,514.23)	88.46
210201	Тэтгэврийн даатгал	93,447,700.00	83,140,637.55	(10,307,062.45)	88.97
210202	Тэтгэмжийн даатгал	10,990,200.00	9,857,948.35	(1,132,251.65)	89.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,496,600.00	4,839,874.14	(656,725.86)	88.05
210204	Ажилгүйдлийн даатгал	5,496,600.00	4,649,571.08	(847,028.92)	84.59
210205	Эрүүл мэндийн даатгал	21,987,200.00	19,069,754.65	(2,917,445.35)	86.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,591,100.00	47,440,392.76	(10,150,707.24)	82.37
210301	Гэрэл, цахилгаан	14,752,900.00	11,719,216.91	(3,033,683.09)	79.44
210302	Түлш, халаалт	27,952,200.00	23,746,482.21	(4,205,717.79)	84.95
210303	Цэвэр, бохир ус	14,886,000.00	11,974,693.64	(2,911,306.36)	80.44
2105	Нормативт зардал	205,539,700.00	187,693,456.00	(17,846,244.00)	91.32
210502	Хоол, хүнс	205,539,700.00	187,693,456.00	(17,846,244.00)	91.32
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00	16,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	16,000,000.00	16,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,682,600.00	4,517,300.00	(165,300.00)	96.47
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,682,600.00	4,517,300.00	(165,300.00)	96.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,663,500.00	46,063,700.00	(8,554,800.00)	84.35

ХТ05430@5012939

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,901,000.00	31,301,200.00	(8,554,800.00)	78.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,762,500.00	14,762,500.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,677,389,700.00	1,558,729,592.76	(118,660,170.24)	92.93
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,495,775,200.00	1,495,775,200.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,495,775,200.00	1,495,775,200.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,591,100.00	62,954,392.76	(10,636,707.24)	85.55
132001	Орон нутгийн төсвөөс	73,591,100.00	62,954,392.76	(10,636,707.24)	85.55
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	108,023,400.00			
120004 32	Урьд оны үлдэгдэлээс санхүүжүүлэх	108,023,400.00			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		108,023,416.19	(108,023,416.19)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		282,839,885.31	(282,839,885.31)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	42.00	(1)	97.67
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	33.00	(1)	97.06
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	413.00	300.00	(113.00)	72.64
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	413.00	300.00	(113.00)	72.64
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	413.00	300.00	(113.00)	72.64
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43.00	42.00	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	29.00	28.00	(1)	96.55
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн	1.00	1.00	-	100.00



	үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)				
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэг нь "Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан байгууллагын менежментийг сайжруулах, үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах, эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх Боловсролын яам, Боловсролын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэхээс гадна дараах зорилтыг дэвшүүлэн ажиллана" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үндэсний хэмжээнд болон Боловсрол, шинжлэх ухааны газраас дэвшүүлсэн зорилтуудаас хамааралтай дараах зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:

- Боловсролын багц хуулийн шинэчлэл болон бусад дүрэм журмыг багш ажилчид, эцэг эх, асран хамгаалагчид олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжүүлэх
- Хүүхэд хамрагдалтыг нэмэгдүүлэх, 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж, сургуульд бэлтгэн оруулах
- Байгууллагын хамтын оролцоо, үнэлгээнд үндэслэн өөрийн онцлог, хэрэгцээ шаардлага, хүүхдийн хөгжилд тулгуурласан менежментийн загвар боловсруулж хэрэгжүүлэх
- Эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил хамгаалал, боловсролын, цогц хөгжлийг дэмжих, явцын үнэлгээнд суурилан хүүхэд бүрийн онцлог ялгаатай байдалд тохируулан хөгжлийн хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж сурлагын амжилтад ахиц гаргах
- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон тэдний хөгжлийг дэмжсэн нэмэлт сургалтыг багш нар болон бусад байгууллагатай хамтран чанартай зохион байгуулж, үр дүнг тооцох
- "Боловсрол-2032" "Чадварлаг багш-Дархан" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, багшийн хөгжилд ахиц гаргах, багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
- Байгууллага хамт олноороо ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, харилцааны эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэх ажлыг шат дараатайгаар зохион байгуулж үр дүнг тооцон ажиллах
- Эцэг эх болон талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлж, хүүхдийн сурч хөгжих ая таатай орчин нөхцлийг бүрдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн журам шинэчлэн батлах тухай" тушаалыг 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс мөрдөж ажиллах
- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 12 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх
- Монгол улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоол "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ыг мөрдөж эхэлсэн,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоол хэрэгжиж эхэлсэн,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болорвсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам" батлагдсан,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавралт өөрчлөн батлах тухай" 84 дүгээр тогтоол батлагдаж зарим албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөн,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ыг мөрдөж эхэлсэн,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай",
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүрийг шинэчлэн батлах тухай" 53 дугаар тогтоолыг мөрдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймаг Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал байна гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн бэлтгэсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 255,272.5 мянган төгрөгөөр буюу 16.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	108,023.5	282,839.9	174,816.4
Авлага	-	-	-
Бараа материал	73,881.0	102,153.1	28,272.1
Үндсэн хөрөнгө	1,374,469.5	1,426,653.6	52,184.1
Нийт хөрөнгө	1,556,374.0	1,811,646.5	255,272.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,556,374.0	1,811,646.5	255,272.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,556,374.0	1,811,646.5	255,272.5

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 282,839.9 мянган төгрөг болж өмнөх оноос 174,816.4 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын цалингийн сангаас

282,436.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 31,422.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 3,386.3 мянган төгрөг, хүүхдийн хоол хүнсний зардлаас 32,895.9 мянган төгрөг, Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 3,238.4 мянган төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардлаас 8,099.0 мянган төгрөгийг хэмнэж Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Дархан-Уул аймийн 5 дугаар цэцэрлэг нь 2024 оны 12 дугаар сарын 31 өдрийн байдлаар өр, авлага гаргаагүй ажилласан.

Бараа материалын дансны үлдэгдэл 102,153.1 мянган төгрөг болж 28,272.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,918.7.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 18,972.3 мянган төгрөгийн барилгын засварын материал, 187,693.5 мянган төгрөгийн хүнсний материал, 300.0 мянган төгрөгийн эм боох материал, 2,478.8 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 23,580.7 мянган төгрөгийн аж ахуйн бараа материалыг орлогоор бүртгэсэн, мөн үндсэн хөрөнгөөс данс хооронд 9,752.5 мянган төгрөгийн аж ахуйн материал шилжүүлэн авсан бөгөөд үйл ажиллагаанд 221,424.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,426,653.6 мянган төгрөг болж 52,184.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 359.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 8,340.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар, 76,095.1 мянган төгрөгний үндсэн хөрөнгийг капиталжуулан авсан, 24,901.5 мянган төгрөгийн хөрөнгийг бусад орлогоор бүртгэн авсан нь шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,811,646.5 мянган төгрөг болж 255,272.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 928,450.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 62,705.3 мянган төгрөг, улсын төсвийн нийт зарлагыг 928,450.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлагыг 62,705.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсөв 1,091,855.9 мянган төгрөг, нийт зардлыг 1,091,855.9 мянган төгрөгөөр буюу 51,423.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж

баталсан нь Засгийн газрын тогтоолоор цалин хөлс нэмэгдсэн, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгосон, нөхөн хангалтын зардал батлагдсан зэргээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвийг 382,556.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,677,389.7 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,495,775.2 мянга, орон нутгийн төсвөөс 65,938.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 2,498.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,384,399.1 мянган төгрөг буюу 82.54 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 282,839.9 мянган төгрөг дутуу зарцуулсантай орон нутгийн төсвөөс 7,652.7 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80233 – Хүүхэд хамгаалал	2,192.7	2,192.7	0.0	100.0
2	81605 - Эрүүл мэндийг дэмжих	5,407.5	2020.0	(3,387.5)	37.4
3	81807-Хүүхдийн хоол	205,539.7	187,693.4	(17,846.3)	91.3
4	81816 - Хүүхдийн ээлтэй сургалтын орчин	6,581.4	6,581.4	0.0	100.0
5	81823 - Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	3,408.5	2,830.0	(578.5)	83.0
6	81834 -Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,357,675.6	1,096,896.5	(260,779.1)	80.8
7	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	22,993.2	22,744.7	(248.5)	98.9
8	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	73,591.1	63,440.4	(10,150.7)	86.2
	Нийт дүн	1,677,389.7	1,384,399.1	(292,990.6)	82.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, багшийн сургалтын зардал, хүүхэд хамгаалал, нөхөн хангалтын зардал, ариутгал цэвэрлэгээний бодис худалдан авах, томилот, бага үнэтэй түргэн элэгдэх зардал, бичиг хэрэг, шуудан холбоо

интернэтийн зардал, төлбөр хураамжийн зардлууд багтсан ба нийт 30,942.2 мянган төгрөг зарцуулсан байна.

2024 онд батлагдсан орон тоо 39 ажилтан албан хаагчтай. Боловсрол шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан орон тооны хязгаарын жишиг нормативын дагуу 42 орон тоотой болж өөрчлөлт орсон.

Ахмадын сангийн судалгаагаар тус цэцэрлэгийн өндөр настан 32 ахмад байгаа боловч ахмадын сан байгуулаагүй байна.

Ахмадын сангийн судалгаагаар тус цэцэрлэгийн өндөр настан 32 ахмад байгаа боловч ахмадын сан байгуулаагүй байна.

Ахмадын сангийн судалгаагаар тус цэцэрлэгийн өндөр настан 32 ахмад байгаа боловч ахмадын сан байгуулаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу 195,398,000 төгрөгийн төсөвт өртгөөр хүүхдийн хоол хүнсний тендерийг 8 удаа зохион байгуулж Тендерт оролцогч ирээгүй учир шууд худалдан авалтыг зохион байгуулж харилцагч байгууллагуудаас үнийн санал авч харьцуулалтын арга ашиглан аль бага үнийн саналтай байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан. 2024 оны 10-р сараас ерөнхий гэрээгээр "Мон-Мийт" ХХК шалгаран гэрээ байгуулан худалдан авалт хийж ажилласан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийн тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 1,163,491.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 23,269.8 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэг нь тодорхой ажлуудыг зохион байгуулж, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 256,228.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлыг 8,554.8 мянган төгрөг, хүүхдийн хоол, мэдээлэл технологийн зардлаас нийт 282,839.9 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Мөн Засгийн газрын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын 2024 онд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 169 мэдээллийг хугацаандаа оруулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан байгууллагын батлагдсан төсөв мэдээллийг 3 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулж байх зөвлөмж өгөх

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийж, нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг үзэж шалгасан ба аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар санхүүгийн тайлангаар 2 зөвлөмж өгсөн зөрчил илэрсэн ба хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	4,408.2	2	4,408.2	100.0
Нийт дүн	2	4,408.2	2	4,408.2	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал 2024 оны эцэст төвлөрүүлсэн цалингийн зардал 240,368.0 мянган төгрөг ба батлагдсан орон тоо 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 42 ажилтантай ажилласан. Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцож цалингийн санг 2024 оны 12 дугаар сарын 28-ний өдөр 115,424.2 мянган төгрөгийг нэмэгдүүлэн санхүүжилтийг олгосон нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Тайлангийн 4.4.1, 4.4.2 дахь хэсэгт дурдсан шилэн дансны тухай хууль болон, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1 шийдвэр мэдээлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	2	-	-	-	-	-	2	-

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.